



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 22 өдөр

Дугаар 8/154

Мандалговь

Г Үндсэн хөрөнгө балансаас балансад Т  
шилжүүлэн, хүлээлгэн өгөх комисс  
томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.3 дах заалт, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 32 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй Сайнцагаан сумын 7 дугаар багийн Худалдааны гудамжийн 2-227 тоотод байрлах, 4809001418 нэгж талбарын дугаар бүхий 414 м<sup>2</sup> талбайтай газрыг Шүүхийн шинжилгээний албандаа хүлээлгэн өгөх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: О.Мөнхзул (Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого , төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Гишүүд: Д.Нандинцэцэг (Нягтлан бодогч)

Б.Баатардорж (Нярав)

Ц.Даваа (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

Хоёр: Тус газрыг 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор эзэмшигчид зохих журмын дагуу хүлээлгэн өгч, тогтоолын хэрэгжилтийн биелэлтийг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүлээлгэн өгөхийг комиссын дарга (О.Мөнхзул)-д үүрэг болгосугай.



488190410